

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/066/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.25 № 1/167  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.АНХТУЯА ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ханх сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,079,862.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 832,340.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 247,521.9 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 9,453.0 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Ханх сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 86.0 хувьтай дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,471,814.73</b>	<b>359,687,932.18</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>92,470,233.73</b>	<b>49,888,277.71</b>
<b>312</b>	Банкинд байгаа бэлэн мөнгө	92,470,233.73	49,888,277.71
<b>3121</b>	Төгрөг	92,470,233.73	49,888,277.71
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>13,353,008.00</b>	<b>247,521,952.93</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	13,353,008.00	247,521,952.93
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>43,648,573.00</b>	<b>62,277,701.54</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>19,578,541.61</b>	<b>20,434,303.14</b>
35130	Эм боох материал	19,578,541.61	20,434,303.14
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>24,070,031.39</b>	<b>41,843,398.40</b>
35410	Бичиг хэргийн материал	1,265,000.00	603,800.00
35420	Аж ахуйн материал	15,660,500.00	28,637,918.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	2,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,100,006.39	6,600,006.40
35460	Хүнсний материал	1,972,525.00	4,001,674.00
35470	Бусад хангамжийн материал	72,000.00	0.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>351,402,170.31</b>	<b>667,086,421.52</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>351,402,170.31</b>	<b>667,086,421.52</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>342,674,170.31</b>	<b>639,094,814.36</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	256,524,340.00	256,524,340.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(69,990,167.83)	(79,461,782.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,530,000.00	326,229,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,170,166.71)	(68,068,035.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	222,762,470.41	304,132,023.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,086,985.54)	(129,270,956.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,467,915.00	40,576,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,363,235.02)	(11,566,741.77)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,728,000.00</b>	<b>27,991,607.16</b>
39301	Програм хангамж	15,550,000.00	15,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,550,000.00)	(15,000,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,728,000.00	29,082,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,090,392.84)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>500,873,985.04</b>	<b>1,026,774,353.70</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>500,873,985.04</b>	<b>1,026,774,353.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>500,873,985.04</b>	<b>1,026,774,353.70</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	288,330,820.00	288,330,820.00
51101	Өмч: - төрийн	288,330,820.00	288,330,820.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>88,488,185.82</b>	<b>614,388,554.48</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	88,488,185.82	88,488,185.82
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	525,900,368.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,054,979.22	124,054,979.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>500,873,985.04</b>	<b>1,026,774,353.70</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>784,162,761.87</b>	<b>1,510,411,841.67</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,738,011.17</b>	<b>403,729,583.45</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>43,738,011.17</b>	<b>403,729,583.45</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,738,011.17	403,729,583.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	33,332,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,738,011.17	370,397,583.45
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>740,424,750.70</b>	<b>1,106,682,258.22</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,066,360.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,476,000.00</b>	<b>26,820,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,476,000.00	26,820,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>706,882,390.70</b>	<b>1,079,862,258.22</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	706,882,390.70	1,079,862,258.22
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>814,020,930.92</b>	<b>980,159,296.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>814,020,930.92</b>	<b>980,159,296.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>812,459,949.46</b>	<b>948,783,278.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>440,368,347.02</b>	<b>585,402,511.68</b>
210101	Үндсэн цалин	269,018,432.48	347,847,167.82
210102	Нэмэгдэл	125,138,292.74	175,435,283.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,665,000.00	13,600,000.00
210104	Урамшуулал	40,914,641.80	48,520,060.00
210105	Гэрээт ажлын хөлс	631,980.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,329,415.05</b>	<b>70,582,441.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,019,332.27	47,531,929.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,510,158.67	5,849,793.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,862,733.30	3,224,267.80
210204	Ажилгүйдлийн даатгал	812,472.03	2,868,032.73
210205	Эрүүл мэндийн даатгал	8,124,718.78	11,108,417.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,242,893.54</b>	<b>15,075,981.85</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,915,018.54	1,855,981.85
210302	Түлш, халаалт	18,327,875.00	11,720,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>81,180,842.11</b>	<b>74,452,074.49</b>
210401	Бичиг хэрэг	13,160,200.00	5,210,800.00
210402	Тээвэр, шатахуун	34,017,540.01	40,220,814.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,618,709.10	3,070,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,704,600.00	6,833,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,679,793.00	19,116,760.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>99,039,795.58</b>	<b>100,566,632.45</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,196,040.58	81,051,101.45
210502	Хоол, хүнс	19,843,755.00	19,515,531.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,779,600.00</b>	<b>17,543,100.00</b>
210604	Урсгал засвар	44,779,600.00	17,543,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,314,900.00</b>	<b>4,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,314,900.00	4,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,871,628.00</b>	<b>5,649,038.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,250,198.00	3,927,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	0.00
210807	Газрын төлбөр	113,430.00	248,613.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	30,925.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,332,528.16</b>	<b>75,011,498.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,006,840.00	6,835,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,325,688.16	68,175,998.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,560,981.46</b>	<b>31,376,018.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>31,332,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	31,332,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,560,981.46</b>	<b>44,018.15</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,560,981.46	44,018.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(29,858,169.05)</b>	<b>530,252,545.38</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>4,352,176.72</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	4,352,176.72
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>(4,352,176.72)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(29,858,169.05)</b>	<b>525,900,368.66</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>727,071,742.70</b>	<b>905,845,313.29</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>33,332,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>33,332,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>33,332,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	33,332,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>727,071,742.70</b>	<b>872,513,313.29</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,066,360.00</b>	<b>0.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,476,000.00</b>	<b>26,820,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	23,476,000.00	26,820,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>693,529,382.70</b>	<b>845,693,313.29</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	693,529,382.70	845,693,313.29
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>672,480,224.68</b>	<b>908,393,269.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>672,480,224.68</b>	<b>908,393,269.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>670,919,243.23</b>	<b>877,017,251.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>438,866,860.08</b>	<b>589,356,521.68</b>
210101	Үндсэн цалин	217,214,691.86	269,733,493.85
210102	Нэмэгдэл	171,685,848.75	257,863,132.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,287,000.00	13,426,181.82
210104	Урамшуулал	45,157,947.40	48,333,714.00
210105	Гэрээт ажлын хөлс	521,372.07	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,278,651.50</b>	<b>70,582,441.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,998,426.58	48,742,449.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,937,029.99	5,687,549.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,076,392.98	2,866,314.52
210204	Ажилгүйдлийн даатгал	875,685.24	2,640,269.62
210205	Эрүүл мэндийн даатгал	8,391,116.71	10,645,858.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,915,018.54</b>	<b>20,075,981.85</b>

210301	Гэрэл, цахилгаан	1,915,018.54	1,855,981.85
210302	Түлш, халаалт	17,000,000.00	16,720,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>57,869,546.10</b>	<b>64,173,304.50</b>
210401	Бичиг хэрэг	8,388,000.00	2,907,790.00
210402	Тээвэр, шатахуун	33,724,940.00	36,720,814.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,743,709.10	3,070,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,805,300.00	6,833,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,207,597.00	14,641,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,590,749.00</b>	<b>89,248,554.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,004,591.00	60,482,034.00
210502	Хоол, хүнс	17,108,158.00	22,016,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,478,000.00	6,750,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,410,000.00</b>	<b>25,026,100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,535,000.00	7,483,000.00
210604	Урсгал засвар	26,875,000.00	17,543,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,314,900.00</b>	<b>4,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,314,900.00	4,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,663,178.00</b>	<b>7,290,848.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,250,198.00	4,012,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	0.00
210807	Газрын төлбөр	113,430.00	248,613.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,791,550.00	1,587,735.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,010,340.00</b>	<b>6,763,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,010,340.00	6,763,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,560,981.46</b>	<b>31,376,018.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>31,332,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	31,332,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,560,981.46</b>	<b>44,018.15</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,560,981.46	44,018.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>54,591,518.02</b>	<b>(2,547,956.02)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,450,000.00</b>	<b>40,034,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,450,000.00</b>	<b>40,034,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,450,000.00</b>	<b>40,034,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,450,000.00	40,034,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(3,450,000.00)</b>	<b>(40,034,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>51,141,518.02</b>	<b>(42,581,956.02)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>41,328,715.71</b>	<b>92,470,233.73</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>92,470,233.73</b>	<b>49,888,277.71</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>118,346,354.86</b>	530,732,154.08
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(29,858,169.05)	(29,858,169.05)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>88,488,185.82</b>	<b>500,873,985.04</b>
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>88,488,185.82</b>	<b>500,873,985.04</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>88,488,185.82</b>	<b>500,873,985.04</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	525,900,368.66	525,900,368.66
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,330,820.00</b>	<b>124,054,979.22</b>	<b>614,388,554.48</b>	<b>1,026,774,353.70</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл:

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,088,324,900.00	921,607,269.31	84.68	166,717,630.69
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,088,324,900.00	921,607,269.31	84.68	166,717,630.69
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,008,324,900.00	890,275,269.31	88.29	118,049,630.69
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	690,219,200.00	589,356,521.68	85.39	100,862,678.32
210101	Үндсэн цалин	336,780,800.00	269,733,493.85	80.09	67,047,306.15
210102	Нэмэгдэл	288,501,700.00	257,863,132.01	89.38	30,638,567.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,000,000.00	13,426,181.82	83.91	2,573,818.18
210104	Урамшуулал	48,936,700.00	48,333,714.00	98.77	602,986.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,277,400.00	70,582,441.13	81.81	15,694,958.87
210201	Тэтгэврийн даатгал	58,668,600.00	48,742,449.55	83.08	9,926,150.45
210202	Тэтгэмжийн даатгал	6,902,200.00	5,687,549.36	82.40	1,214,650.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,451,100.00	2,866,314.52	83.06	584,785.48
210204	Ажилгүйдлийн даатгал	3,451,100.00	2,640,269.62	76.51	810,830.38
210205	Эрүүл мэндийн даатгал	13,804,400.00	10,645,858.08	77.12	3,158,541.92
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,880,500.00	67,673,304.50	98.25	1,207,195.50
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	2,907,790.00	67.49	1,400,910.00
210402	Тээвэр, шатахуун	40,021,000.00	40,220,814.50	100.50	(199,814.50)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	3,070,000.00	101.79	(53,900.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,893,700.00	6,833,700.00	99.13	60,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,641,000.00	14,641,000.00	100.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	89,263,800.00	89,248,554.00	99.98	15,246.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,613,200.00	60,482,034.00	104.98	(2,868,834.00)
210502	Хоол, хүнс	24,900,600.00	22,016,520.00	88.42	2,884,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,750,000.00	6,750,000.00	100.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	54,892,600.00	54,860,100.00	99.94	32,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	26,095,000.00	104.38	(1,095,000.00)
210602	Тавилга	11,939,000.00	10,439,000.00	87.44	1,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,547,200.00	7,483,000.00	99.15	64,200.00
210604	Урсгал засвар	10,406,400.00	10,843,100.00	104.20	(436,700.00)
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,500,000.00	4,500,000.00	100.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,500,000.00	100.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,527,900.00	7,290,848.00	96.85	237,052.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,012,500.00	4,012,500.00	100.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	100.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00	100.00	0.00
210807	Газрын төлбөр	300,000.00	248,613.00	82.87	51,387.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,773,400.00	1,587,735.00	89.53	185,665.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,763,500.00	6,763,500.00	100.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,763,500.00	6,763,500.00	100.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80,000,000.00	31,332,000.00	39.17	48,668,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,000,000.00	31,332,000.00	39.17	48,668,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	31,332,000.00	39.17	48,668,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,088,324,900.00	879,025,313.29	80.77	209,299,586.71
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	952,564,000.00	845,693,313.29	88.78	106,870,686.71
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	952,564,000.00	845,693,313.29	88.78	106,870,686.71
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	135,760,900.00	33,332,000.00	24.55	102,428,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,000,000.00	33,332,000.00	40.65	48,668,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	53,760,900.00		0.00	53,760,900.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	92,470,233.73		(92,470,233.73)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	49,888,277.71		(49,888,277.71)

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,820,000.00</b>	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,820,000.00</b>	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>26,820,000.00</b>	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,120,000.00	20,075,981.85	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,900,000.00	1,855,981.85	<b>97.7</b>	<b>44,018.15</b>
210302	Түлш, халаалт	16,720,000.00	16,720,000.00	<b>100.0</b>	<b>0.00</b>
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	<b>100.0</b>	<b>0.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,700,000.00	6,700,000.00	<b>100.0</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	6,700,000.00	6,700,000.00	<b>100.0</b>	<b>0.00</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,820,000.0	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	26,820,000.0	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>
320001	Орон нутгийн төсвөөс	26,820,000.0	<b>26,775,981.85</b>	<b>99.8</b>	<b>44,018.15</b>

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 9,453.0 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгч, 3,998.0 мянган төгрөгийн 3 алдаа залруулсан.

**3.1 Залруулсан алдаа**

- Орон нутгийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 44,0 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулах бичилтийн залруулга хийсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Цалин хөлсний зардлаас 3,954.0 мянган төгрөгийг бараа материалын зардалд зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн болон зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,455.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,569.3 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

**3.2 Албан шаардлага**

Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 10,609.6 мянган төгрөгийн эм хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч

болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

#### **2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

##### Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 5,455.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид,” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

#### **3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

##### Илрүүлэлт:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системээр үнэн зөв, бүрэн тайлагнаж чадаагүйгээс ЭМДС-аас санхүүжилтийг бүрэн авч чадаагүй, нэхэмжилсэн дүнгээс 49,204.7 мянган төгрөгөөр хасагдсан, санхүүжилт 247,521.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжиж авлага үүсгэсэн байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13

дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

**4. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн асуудал**

**Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд 14 нэр төрлийн 106,920.2 төгрөгийн өртөг бүхий үлдэх өртөггүй хөрөнгө байгаа нь ТӨБЗГын 2019 онд баталсан “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх

**Өгсөн зөвлөмж:**

Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн хөрөнгийг данснаас хасах болон дахин үнэ тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх

**5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 23, зарлагын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 7 шийдвэр, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**6. Ахмадын сангийн талаар**

**Илрүүлэлт:**

Ханх сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1	-	1	-			1	-		
Цалин хөлсний зардлаас 3,954,010 төгрөгийг бараа материалын зардалд зарцуулсан байна	1	3,954.0			1	3,954.0	1	3,954.0		
Орон нутгийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 44.0 мянган төгрөгийн тохируулах бичилт хийгээгүй	1	44.0	1	44.0			1	44.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,998.0</b>	<b>1</b>	<b>44.0</b>	<b>1</b>	<b>3,954.0</b>	<b>3</b>	<b>3,998.0</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна.	1	5,455.0					1	5,455.0
Үндсэн хөрөнгийн дансанд 14 нэр төрлийн 106,920.2 мян төгрөгийн өртөг бүхий үлдэх өртөггүй хөрөнгө байна.	1	0,0					1	0,0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>5,455.0</b>					<b>3</b>	<b>5,455.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1	-			1	-		
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-					1	-
Дүн	4				1		3	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	1	1			1			





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 54/А2270469/

Мөрөн сум

ХДА - 2025/066/НА - СГН - ТИЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ханх сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 10,609,600 (Арван сая зургаан зуун есөн мянга зургаан зуу) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Анхтуяа, нягтлан бодогч Б.Бямбажаргал нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО



6724030565